



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/570

Зуунмод

“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг 2022 оны 10 дугаар сарын 08-ны өдөр аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, шаардагдах зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн арга хэмжээнд шаардагдах 24,290,000 (хорин дөрвөн сая долоон зуун ерэн мянга) төгрөгийн зардлын төсвийг Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т зөвшөөрсүгэй

4. Мод тарих ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж, тарьсан мод бут сөөгийг иргэд, аж ахуйн нэгжүүдэд хариуцуулан арчилгаа хамгаалалтыг хийлгэж, холбогдох мэдээ тайланг Засаг даргад танилцуулж, удирдах дээд байгууллагуудад хүргэж ажиллахыг Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга (Ж.Даш-Яйчил)-д үүрэг болгосугай.


5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг улирал бүр тооцож ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Д.Саран-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 06 -ны өдрийн А/570 дугаар захирамжийн хавсралт



“БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ ӨДӨР”-ИЙН
ЗАРДЛЫН ТООЦОО.

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
1	Хулдаасан хэвлэлийн зардал	М ²	12000	20	240,000
2	Хайлаас	ширхэг	1500	3000	4,500,00
3	Агч	ширхэг	1500	6000	9,000,000
4	Шар хуайс	ширхэг	1000	5000	5,000,000
5	Мөнгөн урамшуулал, өргөмжлөл	Шилдэг сумдууд	1-3 байр	1-р байр- 1,000,000 2-р байр- 900,000 2-р байр- 800,000	2,700,000
		Аж ахуйн нэгж байгууллагууд	5 байгууллага	300,000	1,500,000
		Айл өрх	9 айл өрх	150,000	1,350,000
Нийт дүн					24,290,000

___оОо___

